**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

***Халхгол сумын Нөмрөгийн Дархан Цаазат газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/112/СТА-ТШЗ***

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Аудитор: Э.Нандинчимэг
Утас: 7000-3775 Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8
3.Аудитын тайлан....9
3.1. Ерөнхий зүйл....9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт....9
3.4. Материаллаг байдал....9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт....10
3.7. Шилэн дансны мэдээлэл....11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....11
3.9. Аудитын илрүүлэлт....12
Залруулсан алдаа....12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....13

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 303

танай ____________-ны №____________-т

ХАЛХ ГОЛ НӨМРӨГИЙН ДАРХАН
ЦААЗАТ ГАЗРЫН ДАРГА
Ч.ЧИНБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол нөмрөгийн Дархан цаазат газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол Нөмрөгийн Дархан цаазат газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Халхгол Нөмрөгийн Дархан цаазат газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020283

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **19,600,288.00** | **19,475,118.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 19,600,288.00 | 19,475,118.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,700,288.00 | 9,575,118.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 118,722.00 | 72,152.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 436,800.00 | 294,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,144,766.00 | 9,208,166.00 |
| 35600 | Мал амьтад | 9,900,000.00 | 9,900,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **163,831,203.94** | **210,497,432.95** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 163,831,203.94 | 210,497,432.95 |
| **392** | **Биет хөрөнгө** | 123,831,203.94 | 170,147,432.95 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 43,025,265.00 | 43,025,265.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,494,508.80) | (2,989,017.60) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 49,294,000.00 | 113,379,073.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (16,986,583.22) | (24,157,108.29) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 45,109,558.81 | 45,109,558.81 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,446,516.79) | (25,875,962.90) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,665,118.43 | 10,635,118.43 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (4,176,160.88) | (5,325,195.43) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 20,762,642.86 | 25,237,642.86 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,921,611.47) | (8,891,941.71) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 40,000,000.00 | 40,350,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40,350,000.00 | 40,350,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (350,000.00) | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **183,431,491.94** | **229,972,550.95** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **183,431,491.94** | **229,972,550.95** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 183,431,491.94 | 229,972,550.95 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 155,495,650.00 | 155,495,650.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 155,495,650.00 | 155,495,650.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 27,935,841.94 | 74,476,900.95 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 27,935,841.94 | 27,935,841.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 46,541,059.01 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **183,431,491.94** | **229,972,550.95** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **163,478,513.52** | **284,724,473.78** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **18,076,113.52** | **66,942,173.78** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 18,076,113.52 | 66,942,173.78 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 18,076,113.52 | 66,942,173.78 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 92,100.00 | 527,100.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 17,984,013.52 | 66,415,073.78 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **145,402,400.00** | **217,782,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 132,502,400.00 | 217,782,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 132,502,400.00 | 217,782,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,900,000.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 12,900,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **152,728,507.04** | **238,183,414.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **152,728,507.04** | **238,183,414.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 148,966,340.04 | 210,558,857.77 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 94,452,812.00 | 112,044,060.00 |
| 210101 | Үндсэн цалин | 71,606,173.00 | 79,605,846.00 |
| 210102 | Нэмэгдэл | 14,590,741.00 | 24,262,191.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,485,000.00 | 2,845,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,770,898.00 | 5,331,023.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,806,601.90 | 15,433,123.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,028,502.00 | 10,604,423.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 977,460.90 | 1,207,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 722,681.00 | 965,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 188,901.00 | 241,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,889,057.00 | 2,414,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,641,116.00 | 4,444,015.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 386,100.00 | 386,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,255,016.00 | 4,057,915.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,916,557.00 | 16,984,414.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 686,357.00 | 529,570.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,942,100.00 | 15,006,620.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 581,600.00 | 1,068,124.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 706,500.00 | 380,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 245,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 67,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 178,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 137,300.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 137,300.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,963,200.00 | 2,367,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,963,200.00 | 2,367,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,152,640.00 | 34,488,201.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,592,600.00 | 33,575,641.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 260,000.00 | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 177,840.00 | 221,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 46,000.00 | 51,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 220,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,200.00 | 62,060.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,896,113.14 | 24,552,344.77 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 467,000.00 | 328,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,429,113.14 | 24,223,844.77 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,762,167.00 | 27,624,557.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,762,167.00 | 27,624,557.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,762,167.00 | 27,624,557.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,750,006.48** | **46,541,059.01** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **10,750,006.48** | **46,541,059.01** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **145,494,500.00** | **218,309,400.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **92,100.00** | **527,100.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 92,100.00 | 527,100.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 92,100.00 | 527,100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 92,100.00 | 527,100.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **145,402,400.00** | **217,782,300.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 132,502,400.00 | 217,782,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 132,502,400.00 | 217,782,300.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,900,000.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 12,900,000.00 | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **145,494,500.00** | **218,309,400.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **145,494,500.00** | **218,309,400.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **141,732,333.00** | **190,684,843.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 94,452,812.00 | 112,044,060.00 |
| 210101 | Үндсэн цалин | 71,606,173.00 | 79,605,846.00 |
| 210102 | Нэмэгдэл | 14,590,741.00 | 24,262,191.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,485,000.00 | 2,845,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,770,898.00 | 5,331,023.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,773,665.00 | 15,433,123.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,028,502.00 | 10,604,423.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 944,524.00 | 1,207,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 722,681.00 | 965,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 188,901.00 | 241,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,889,057.00 | 2,414,300.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,691,116.00 | 4,374,015.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 386,100.00 | 386,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,305,016.00 | 3,987,915.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 3,207,000.00 | 16,636,144.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 471,200.00 | 349,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,942,100.00 | 15,006,620.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 581,600.00 | 1,068,124.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 212,100.00 | 212,100.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 178,200.00 | 178,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 178,200.00 | 178,200.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 339,300.00 | 202,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 202,000.00 | 202,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 137,300.00 | - |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 1,963,200.00 | 2,367,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,963,200.00 | 2,367,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,760,040.00 | 39,121,101.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,200,000.00 | 38,208,541.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 260,000.00 | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 177,840.00 | 221,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 46,000.00 | 51,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 220,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,200.00 | 62,060.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,367,000.00 | 329,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,900,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 467,000.00 | 329,200.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,762,167.00** | **27,624,557.00** |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,762,167.00 | 27,624,557.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,762,167.00 | 27,624,557.00 |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **155,495,650.00** | **00.00** | **27,935,841.94** | **00.00** | 183,431,491.94 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **155,495,650.00** | **00.00** | **27,935,841.94** | **00.00** | 183,431,491.94 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **155,495,650.00** | **00.00** | **27,935,841.94** | **00.00** | 183,431,491.94 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 46,541,059.01 | 00.00 | 46,541,059.01 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **155,495,650.00** | **00.00** | **74,476,900.95** | **00.00** | 229,972,550.95 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 134,702,400.00 | 141,732,333.00 | 219,982,300.00 | 190,684,843.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 134,702,400.00 | 141,732,333.00 | 219,982,300.00 | 190,684,843.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 134,702,400.00 | 141,732,333.00 | 219,982,300.00 | 190,684,843.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 98,994,200.00 | 94,452,812.00 | 120,719,300.00 | 112,044,060.00 |
| 210101 | Үндсэн цалин | 73,510,700.00 | 71,606,173.00 | 83,229,800.00 | 79,605,846.00 |
| 210102 | Нэмэгдэл | 17,100,000.00 | 14,590,741.00 | 27,628,300.00 | 24,262,191.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,562,300.00 | 2,485,000.00 | 3,430,300.00 | 2,845,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,821,200.00 | 5,770,898.00 | 6,430,900.00 | 5,331,023.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 12,374,400.00 | 11,773,665.00 | 16,296,900.00 | 15,433,123.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,414,600.00 | 8,028,502.00 | 11,468,200.00 | 10,604,423.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 990,000.00 | 944,524.00 | 1,207,200.00 | 1,207,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 791,900.00 | 722,081.00 | 965,800.00 | 965,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 198,000.00 | 188,901.00 | 241,400.00 | 241,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,979,900.00 | 1,889,057.00 | 2,414,300.00 | 2,414,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,380,900.00 | 3,691,116.00 | 4,580,400.00 | 4,374,015.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 386,100.00 | 386,100.00 | 386,100.00 | 386,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,945,000.00 | 3,305,016.00 | 4,100,800.00 | 3,987,915.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,207,000.00 | 3,207,000.00 | 18,097,600.00 | 16,636,144.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 471,200.00 | 471,200.00 | 349,300.00 | 349,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,942,100.00 | 1,942,100.00 | 16,466,300.00 | 15,006,620.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 581,600.00 | 581,600.00 | 1,069,900.00 | 1,068,124.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 212,100.00 | 212,100.00 | 212,100.00 | 212,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 178,200.00 | 178,200.00 | 178,200.00 | 178,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 178,200.00 | 178,200.00 | 178,200.00 | 178,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 339,300.00 | 339,300.00 | 202,000.00 | 202,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 202,000.00 | 202,000.00 | 202,000.00 | 202,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,963,200.00 | 1,963,200.00 | 2,368,000.00 | 2,367,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,963,200.00 | 1,963,200.00 | 2,368,000.00 | 2,367,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,798,200.00 | 12,760,040.00 | 57,210,700.00 | 39,121,101.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,200,000.00 | 12,200,000.00 | 56,141,700.00 | 38,208,541.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 260,000.00 | 260,000.00 | 270,000.00 | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 177,600.00 | 177,840.00 | 221,400.00 | 221,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 64,300.00 | 46,000.00 | 159,600.00 | 51,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,800.00 | 00.00 | 88,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 | 250,000.00 | 220,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,200.00 | 76,200.00 | 80,000.00 | 62,060.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 467000.00 | 467000.00 | 329200.00 | 329200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 467,000.00 | 467,000.00 | 329,200.00 | 329,200.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 134,702,400.00 | 141,732,333.00 | 217,782,300.00 | 217,782,300.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 134,702,400.00 | 141,732,333.00 | 217,782,300.00 | 217,782,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 134,702,400.00 | 141,732,333.00 | 217,782,300.00 | 217,782,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 134,702,400.00 | 141,732,333.00 | 217,782,300.00 | 217,782,300.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,200,000.00 | 92,100.00 | 2,200,000.00 | 527,100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,200,000.00 | 92,100.00 | 2,200,000.00 | 527,100.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01 | 01 | 01 | 01 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 11 | 11 | 15 | 15 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 06 | 06 | 06 | 06 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 03 | 03 | 04 | 04 |
| 620004 | Гэрээт ажилтан | 01 | 01 | 04 | 04 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Нөмрөгийн Дархан Цаазат газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ч.Чинбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 10–ы хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Халхгол сумын Нөмрөгийн Дархан Цаазат газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Халхгол сумын Нөмрөгийн Дархан цаазат газрын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн эко системийг унаган төрхөөр нь хамгаалах хяналт шалгалт ,судалгаа шинжилгээ,сургалт сурталчилгаа,аялал жуулчлал

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Халхгол сумын Нөмрөгийн Дархан Цаазат газрын захиргааны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Халхгол сумын Нөмрөгийн Дархан Цаазат газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 238,183.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 4,763.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Халхгол сумын Нөмрөгийн Дархан Цаазат газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,042.8 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 19,600.2 | 19,475.1 | -125.1 |
| Үндсэн хөрөнгө | 163,831.2 | 210,497.4 | 46,666.2 |
| **Нийт хөрөнгө** | **183,431.4** | **229,972.5** | **46,541.1** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 183,431.4 | 229,972.5 | 46,541.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **183,431.4** | **229,972.5** | **46,541.1** |

Бараа материалын дансны үлдэгдэл 19,475.1 мянган төгрөг болж 125,1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 210,497.43 мянган төгрөг болж 46,666.2 мянган төгрөгөөр өссөн нь ИХТ-ын тогтоолын дагуу 1,980.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 48,646.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталасан 1,980.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 229,972.55 мянган төгрөг болж 46,541.06 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө орлого авснаас шалтгаалжээ.

Халхгол сумын Нөмрөгийн Дархан Цаазат газрын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 284,724.47 мянган төгрөгөөр буюу 57.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 61,592.51 мянган төгрөгөөр буюу 41.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 219,982.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 219,982.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 219,982.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 217,782.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,200.0 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 217,782.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, төлөвлөгөөт орлогоос 527.1 мянган төгрөгийг олж, нийт 218,309.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 190,684.8 мянган төгрөгийг зарцуулж 27,624.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 190,684.8 мянган төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 8,675.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл 863.7 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 1,459.6 мянган төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг 17,933.2 төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь ковид-19 цар тахал гарснаас үүдэн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өөрийн үйл ажиллагаанаас 527.1 мянган төгрөгийн орлого орсон байна.

Үнээс бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсэд 517.1 мянган төгрөгийг зарцуулжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө биелэхгүй байгаатай холбогдуулан нэвтрэх хураамжийн тасалбарын үнэ нэмэгдүүлэх саналыг БОАЖЯамны санхүүгийн хэлтэст хүргүүлсэн боловч шийдвэр гаргаагүй байна. Мөн ээлжийн амралтын мэдэгдлийн буруу маягт ашигласан гэсэн зөвлөмжийн дагуу Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын 166 тоот тушаалын дагуу маягтыг ээлжийн амралт тооцоолох маягтад ашигласан байна. Өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлт 60 хувьтай хэрэгжсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,371.2. мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 146.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 17,255.0 мянган төгрөгийн зөрчилд 233.7 мянган төгрөгийн акт тогтоож, 16,991.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Хуримтлагдсан элэгдлийг 146.2 мянган төгрөгийн элэгдлийг зөрүүтэй тооцоолсныг дахин тооцоолон залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 17,255.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 233.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 16,991.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 233.7 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.10 дахь "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Дээд шатны байгууллагаас тайлант онд 2,200.0 мянган төгрөгийн төлөвлөгөөт орлогыг баталсан бөгөөд шалгагдагч байгууллага нь 527.1 мянган төгрөг буюу 23.9 хувийн биелэлттэй, 1,672.9 мянган төгрөг буюу 76.1 хувийг биелүүлж чадаагүй нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант хугацаанд гарсан зардлаас 15,318.4 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитад төлбөрийн цахим системийн анхан шатны баримтын бүрдэлтийг анхааран үзэхийг зөвлөж хангалтгүй гэж үзлээ.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Аудитын код: |
|---|---|---|
| 2020 | ***Халхгол сумын Нөмрөгийн Дархан цаазат газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | ДОА 2021/112/СТА-ТШЗ |

Шалгагдсан байгууллагын нэр: **Халхгол сумын Нөмрөгийн Дархан цаазат газрын захиргаа**

Мянган төгрөг

| | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлант хугацааны шатахуун зарцуулалтыг жишиг нормоор тооцох | 233.7 | Төлбөрийн акт | Дарга Нягтлан бодогч | Ч.Чинбат Д.Дулмаа |
| 2 | Шилэн дансны мэдээллийг хоцроож байршуулсан | - | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Ч.Чинбат Д.Дулмаа |
| 3 | Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй | 1,672.9 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Ч.Чинбат Д.Дулмаа |
| 4 | Төлбөрийн цахим баримтад дутуу баримт илгээгдсэн | 15,318.4 | Албан шаардлага | Дарга Нягтлан бодогч | Ч.Чинбат Д.Дулмаа |
| | **ДҮН** | **17,225.0** | | | |